

**БАНК, САНХҮҮГИЙН САЛБАР**

ТАНИЛЦУУЛГА

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДААНЫ ГАЗАР**

УЛААНБААТАР ХОТ

2026

**Агуулга**

1. УДИРТГАЛ	3
1.1. Банк, санхүүгийн салбарын өнөөгийн байдал	3
1.2. Банкны зах зээлийн бүтэц, үйлчилгээний хамрах хүрээ	4
1.3. Санхүүгийн гол бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт	5
1.4. Монгол Улсад эрэлттэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ	6
2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖТОЙ ЧИГЛЭЛ	7
2.1. Хөрөнгө оруулалт ба зах зээлийн боломж	7
2.2. Гадаадын шууд хөрөнгө оруулалт	7
2.3. Банк, санхүүгийн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө ба гадаад хөрөнгө оруулалт	8
2.4. Хөрөнгийн зах зээлийн хөгжил	9
2.5. Хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-уудын салбарын ангилал	10
2.6. Хөрөнгийн зах зээлийн бүтцийн шинжилгээ	11
2.7. Санхүүгийн салбар дахь хөрөнгө оруулалтын боломж	12
3. ЭРХ ЗҮЙ, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН	13
3.1. Гадаадын банк Монголд орж ирэх боломж	14
3.2. Яагаад гадаад банк орж ирэх нь давуу байж болох вэ	15
3.3. Яагаад бодит амьдрал дээр амаргүй вэ	15
3.4. Эрсдэл, тогтвортой байдлын асуудал	15
ДҮГНЭЛТ	16
ЭХ СУРВАЛЖ	17

Монгол Улсын банк, санхүүгийн салбар нь 2020–2025 оны хугацаанд тогтвортой өсөлттэй байсан бөгөөд банк төвтэй бүтэц давамгай хэвээр байна. Хөрөнгийн зах зээл болон банк бус санхүүгийн сегментүүд хурдацтай тэлж байгаа нь санхүүгийн систем аажмаар төрөлжиж байгааг харуулж байна. Гэвч макро эдийн засгийн эрсдэл, зээлийн өсөлтийн хурд нь бодлогын түвшинд анхаарах шаардлагатай хэвээр байна.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол Улсын банк, санхүүгийн салбарын өнөөгийн байдал, зах зээлийн бүтэц, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт, финтек болон цахим санхүүгийн хөгжлийн түвшин, эрх зүйн зохицуулалтын орчин, мөн Гадаадын банк Монголд орж ирэх боломж, салбарын эрсдэл ба тогтвортой байдлын асуудлыг судалж дүгнэлт гаргахад оршино.

### **1.1. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Монголын санхүүгийн системийн гол тулгуур нь банкны салбар хэвээр байна. Монголбанк 2024 оны жилийн тайландаа банкны салбарын нийт актив 71.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 25.1 хувиар өссөн, чанаргүй зээлийн харьцаа 4.3 хувь болж сүүлийн жилүүдийн доод түвшинд очсон байна.

Энэ нь банкны салбар хэмжээний хувьд тэлж, активын чанар 2024 оны эцэст сайжирсныг харуулж байна.


СЗХ-ны 2024 оны жилийн тайланд хөрөнгийн зах зээл, даатгал, ББСБ, ХЗХ зэрэг СЗХ-ны зохицуулалттай салбарууд нийлээд ДНБ-ий 26.5 хувьтай тэнцсэн.

Өөрөөр хэлбэл, Монголын санхүүгийн систем банк давамгай хэвээр боловч банкнаас бусад сегментүүдийн жин бодитоор нэмэгдэж байна.

ОУВС 2025 оны Article IV тайландаа 2024 оны бодлогын зөөлрөл, төсвийн тэлэлт нь зээлийн өсөлтийг хурдасгаж, импорт өсөх, урсгал дансны алдагдал тэлэх, инфляц зорилтот түвшнээс дээш гарахад нөлөөлсөн гэж дүгнэсэн.

Мөн 2025 оны эхний хагаст нүүрсний экспортын орлого саарч, ойрын хугацааны эрсдэл нэмэгдсэнийг онцолсон.

### 2025 оны санхүүгийн салбарын гол үзүүлэлтүүд



2025 оны байдлаар хөрөнгийн зах зээл 13.2 их наяд төгрөгт хүрч, ББСБ салбар 8.5 их наяд актив, 7.0 их наяд зээлтэй болсон нь банкнаас бусад санхүүжилт эрчимтэй тэлж байгааг харуулж байна.

## 1.2. ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

Монголын санхүүгийн зах зээл нь дараах үндсэн байгууллагуудаас бүрддэг.

Салбар	Үндсэн үйлчилгээ	Зах зээлийн үүрэг
<b>Арилжааны банк</b>	Хадгаламж, зээл, төлбөр	Санхүүгийн системийн гол хэсэг
<b>ББСБ</b>	Жижиг зээл, санхүүжилт	ЖДБ-ийг дэмжих
<b>Даатгал</b>	Эрсдэлийн хамгаалалт	Санхүүгийн хамгаалалт
<b>Хөрөнгийн зах зээл</b>	Хувьцаа, бонд	Хөрөнгө оруулалт татах

<b>Финтек</b>	<b>Дижитал төлбөр</b>	<b>Инновац, хүртээмж</b>
---------------	-----------------------	--------------------------

Эдгээр байгууллагууд нь санхүүгийн зуучлал, хөрөнгө оруулалт, эрсдэлийн хамгаалалт, төлбөр тооцооны үйлчилгээ зэрэг олон төрлийн санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлдэг.

### 1.3. САНХҮҮГИЙН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРЭЛТ

Монголын банк, санхүүгийн салбарт хамгийн эрэлттэй бүтээгдэхүүнүүд нь уламжлалт хадгаламж, бизнесийн болон хэрэглээний зээл, ипотекийн зээл, картын үйлчилгээ, гадаад гуйвуулга, төлбөр тооцоо, мөн ББСБ-ын жижиг дүнтэй хурдан санхүүжилт юм.

Банкны салбарын өсөлттэй зэрэгцэн иргэдийн хэрэглээний зээл, бизнесийн санхүүжилт, ялангуяа худалдаа, үйлчилгээ, уул уурхай дагасан зээлийн эрэлт өссөн гэж банкны салбарын улирлын тоймууд тэмдэглэсэн.

Технологийн тал дээр Монголын салбар сүүлийн 2-3 жилд нэлээд хурдтай шинэчлэгдсэн. Монголбанк 2024 онд үндэсний төлбөрийн системийн журмуудаа шинэчилж, QR кодын мессежийн бүтцийг шинэчлэн, 2024 оны 9 сард финтекийг дэмжих Innovation Office байгуулсан. Мөн 2024 онд Apple Pay-г дотоодын түнш банкуудтай хамт нэвтрүүлсэн нь Монголын картын болон дижитал төлбөрийн экосистем олон улсын шийдэлтэй холбогдож эхэлснийг харуулж байна.

СЗХ-ны 2025 оны I, II, III улирлын тоймуудаас харахад хөрөнгийн зах зээл дээр хувьцаа, бонд, хувийн үнэт цаас, хамтын санхүүжилт, хөрөнгөөр баталгаажсан бүтээгдэхүүнүүд аажмаар олширч байна. TOP-20 индексийн бүтцэд банк, санхүүгийн салбар 2025 оны I улиралд 64.7 хувийн жинтэй байсан нь энэ салбар хөрөнгийн зах зээлийн үнэлгээний том хөдөлгөгч хэвээр байна.

### 1.4. Монгол Улсад эрэлттэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Тайлбар	Эрэлтийн түвшин	Гол хэрэглэгч
1	<i>Хэрэглээний зээл</i>	<i>Иргэдийн өдөр тутмын хэрэгцээг санхүүжүүлэх зээл</i>	Маш өндөр	Иргэд
2	<i>Бизнесийн зээл</i>	<i>Жижиг, дунд болон том бизнесийн үйл ажиллагааг дэмжих санхүүжилт</i>	Өндөр	ААН
3	<i>Ипотекийн зээл</i>	<i>Орон сууц худалдан авах урт хугацааны зээл</i>	Өндөр	Өрх, иргэд

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Тайлбар	Эрэлтийн түвшин	Гол хэрэглэгч
4	<i>Хадгаламж</i>	<i>Мөнгөн хөрөнгийг хадгалж, хүүгийн орлого олох үйлчилгээ</i>	Маш өндөр	Иргэд, ААН
5	<i>Даатгал</i>	<i>Эрсдэлийг бууруулах, хамгаалах санхүүгийн үйлчилгээ</i>	Дунд	Иргэд, ААН
6	<i>Цахим төлбөрийн үйлчилгээ</i>	<i>QR, мобайл банк, карт, онлайн төлбөр</i>	Маш өндөр	Бүх хэрэглэгч

Монгол Улсад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт нь хэрэглэгчийн хэрэгцээ, эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран ялгаатай байгаа бөгөөд хэрэглээний зээл, хадгаламж, цахим төлбөрийн үйлчилгээ хамгийн өндөр эрэлттэй байна. Top of Form Bottom of Form

Ялангуяа жижиг, дунд бизнесийн санхүүжилт болон дижитал зээлийн үйлчилгээ сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч байна.

## 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖТОЙ ЧИГЛЭЛ

### 2.1. Хөрөнгө оруулалт ба зах зээлийн боломж

Монгол Улсын банк, санхүүгийн салбар нь сүүлийн жилүүдэд тогтвортой өсөлттэй байж, дотоод болон гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломж аажмаар нэмэгдэж байна.

Санхүүгийн зах зээлийн бүтэц банк төвтэй хэвээр байгаа хэдий ч банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгийн зах зээл, финтек үйлчилгээ зэрэг дэд салбаруудын хөгжил нь хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг бий болгож байна.

Түүнчлэн макро эдийн засгийн нөхцөл, экспортын бүтэц, гадаад орчны нөлөөлөл нь санхүүгийн зах зээлд шууд нөлөөлдөг бөгөөд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад чухал хүчин зүйл болж байна. Иймд банк, санхүүгийн салбар дахь хөрөнгө оруулалтын орчин, боломж, эрсдэлийг цогцоор нь авч үзэх шаардлагатай юм.

Эдгээр чиглэлүүд нь санхүүгийн инновацийг дэмжих, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжийг бий болгодог.

### 2.2. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)

Монгол Улсын банк, санхүүгийн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) нь нийт эдийн засагт эзлэх хувиар харьцангуй бага боловч сүүлийн жилүүдэд тогтвортой өсөлтийн хандлагатай байна.

1990–2025 оны хугацаанд Монгол Улсад нийт орж ирсэн ГШХО-оос банк, санхүүгийн салбарын эзлэх хувь ойролцоогоор 3–4 хувь байгаа ба нийт 52.2 тэрбум ам.долларын ГХО орж ирсэн.

Үүнээс: Банк, санхүүгийн салбарт 2.1 тэрбум ам.доллар буюу 3.9% нь орж ирсэн.

Тус салбарт сүүлийн 5 жил 680.1 сая ам.доллар орж ирсэн нь нийт тус салбарт орж ирсэн ГХО-ын 3/1-ийг эзэлж байна.

Уг салбарын олон улсын хөрөнгө оруулалт татах боломж бүрэн ашиглагдаагүй байгааг харуулж байна.

ГШХО бага байгаа шалтгаан нь зах зээлийн хэмжээ хязгаарлагдмал, хөрөнгийн зах зээлийн гүнзгийрэлт сул, валютын ханшийн савлагаа, макро эдийн засгийн тогтворгүй байдал зэрэгтэй холбоотой. Гэсэн хэдий ч санхүүгийн салбарын дижитал шилжилт, финтекийн хөгжил, банкны салбарын ил тод байдал нэмэгдэж байгаа нь цаашид гадаадын хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлж байна.

Ирээдүйд финтек, дижитал банк, төлбөрийн систем, ногоон санхүүжилт зэрэг чиглэлүүд нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах хамгийн боломжтой салбарууд гэж үзэж байна.


### 2.3. Банк, санхүүгийн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө ба гадаад хөрөнгө оруулалт

2025 оны байдлаар банк, санхүүгийн салбар нь Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д мэдэгдэхүйц хувь нэмэр оруулж, эдийн засгийн бүтцэд чухал байр суурь эзэлж байна. Энэ нь тус салбар эдийн засгийн идэвхжил, мөнгөний эргэлтийг хангах, төлбөр тооцооны системийг тогтвортой ажиллуулах үндсэн механизм болж байна.

ДНБ-д эзлэх банк, санхүүгийн салбарын бүтэц

**Нийт, ДНБ 2025 онд 89.9 их наяд төгрөг  
онд 5.2 их наяд төгрөг**

**БСС, ДНБ 2025**



2025 оны байдлаар Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 89.9 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс банк, санхүүгийн салбар 5.2 их наяд төгрөгийн хувь нэмэр



INVESTMENT AND  
TRADE AGENCY




оруулж байна. Энэ нь тус салбар нийт эдийн засгийн ойролцоогоор **5.8 орчим хувийг** бүрдүүлж байгааг харуулж байна.

**ГХО-тай банк, санхүүгийн салбарын ААН**

2024 он			2025 он		
Ажил олгогчийн тоо	Даатгуулагчийн тоо	Дундаж цалин сая.төг / 1 сар	Ажил олгогчийн тоо	Даатгуулагчийн тоо	Дундаж цалин сая.төг / 1 сар
11	299	1.59	12	328	1.94

2024 онд тус салбарын ажиллагчдын дундаж цалин 2.89 сая төгрөг байсан. ГХО-тай тус салбарт ажиллаж буй даатгуулагчдын дундаж цалин гадаад, дотоодын нийт ажиллагчдын дундаж цалингаас 1.3 сая төгрөг буюу (45.0%)-иар бага байна.

**Банк, санхүүгийн салбарын ажиллагчид**



Банк, санхүүгийн салбарын ажиллагчдын тоо сүүлийн жилүүдэд тодорхой хэлбэлзэлтэй байсан боловч 2024 онд мэдэгдэхүйц өсөлт ажиглагдаж байна. Тухайлбал, ажиллагчдын тоо 2020 онд 30,018 байсан бол 2021–2023 онд дараалан буурч 22,139-д хүрсэн байна. Харин 2024 онд 30,519 болж өмнөх оноос 37.9 хувиар өссөн нь салбар дахин идэвхжиж, хөдөлмөрийн эрэлт нэмэгдсэнийг илтгэж байна.

Салбарын ажиллах хүч болон цалин тогтвортой өсч байгаа нь банк, санхүүгийн салбар эдийн засгийн чухал, өсөн тэлж буй салбар гэдгийг харуулж байна.

## 2.4. Хөрөнгийн зах зээлийн хөгжил

Монгол Улсын хөрөнгийн зах зээл нь хөгжлийн шатандаа байгаа боловч сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц өсөлт ажиглагдаж байна. 2025 оны байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 13.19 их наяд төгрөгт хүрч, өмнөх жилүүдтэй харьцуулахад өссөн нь зах зээлийн идэвхжил нэмэгдэж байгааг харуулж байна.

- Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, их наяд төгрөг
- Хувьцааны хоёрдогч зах зээлд хөрвөх чадвар 2025 онд 2.1% байна.



## 2.5. Хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-уудын салбарын ангилал

№	Салбар	Эзлэх хувь (%)
1	Аж үйлдвэр	28.8%
2	Банк, санхүү	23.1%
3	Барилга	10.9%
4	Уул уурхай	10.2%
5	Газар тариалан, мал аж ахуй	8.3%
6	Бусад	9.0%
7	Худалдаа, зочид буудал, нийтийн хоол	4.5%
8	Тээвэр, ложистик	2.6%
9	Аялал жуулчлал	1.3%

№	Салбар	Эзлэх хувь (%)
10	Харилцаа холбоо	1.3%

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын салбарын бүтцээс харахад аж үйлдвэр (28.8%) болон банк, санхүүгийн салбар (23.1%) хамгийн өндөр жин эзэлж байна.

Хөрөнгийн зах зээлд банк, санхүүгийн салбарын компаниуд өндөр жин эзэлж байгаа бөгөөд энэ нь уг салбар зах зээлийн гол хөдөлгөгч хүч болж байгааг илтгэнэ. Мөн сүүлийн жилүүдэд IPO, бонд гаргалт, хувийн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүд нэмэгдэж байгаа нь зах зээлийг өргөжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Гэсэн хэдий ч зах зээлийн хөрвөх чадвар сул, хөрөнгө оруулагчдын суурь хязгаарлагдмал, мэдээллийн ил тод байдал бүрэн хангагдаагүй зэрэг асуудлууд нь зах зээлийн цаашдын хөгжилд саад болж байна.

## 2.6. Хөрөнгийн зах зээлийн бүтцийн шинжилгээ

- Үйлчилгээний гадаад худалдаа, банк, санхүүгийн салбар



Банк, санхүүгийн салбар нь үйлчилгээний экспорт, импортын аль алинд оролцож, валютын урсгал болон төлбөрийн тэнцэлд чухал нөлөө үзүүлдэг бөгөөд энэ нь салбарын олон улсын интеграц нэмэгдэж байгааг илтгэнэ.

## 2.7. Санхүүгийн салбар дахь хөрөнгө оруулалтын боломж

Монгол Улсын банк, санхүүгийн салбарт дараах үндсэн чиглэлүүдэд хөрөнгө оруулалтын боломж өндөр байна:



INVESTMENT AND  
TRADE AGENCY



Чиглэл	Тайлбар	Өсөлтийн түвшин	Боломж
Финтек	QR төлбөр, мобайл банк, онлайн зээл	Маш өндөр	★★★★★
ББСБ	ЖДБ санхүүжилт	Өндөр	★★★★
Хөрөнгийн зах зээл	IPO, бонд	Дунд	★★★
Ногоон санхүү	Тогтвортой хөгжил	Дунд	★★★

Санхүүгийн салбарт хамгийн өндөр өсөлттэй, хөрөнгө оруулалтын боломжтой чиглэл нь финтек бөгөөд ББСБ болон хөрөнгийн зах зээл дараагийн түвшинд байна.

Эдгээр чиглэлүүд нь санхүүгийн салбарын төрөлжилтийг нэмэгдүүлж, гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах чухал боломжийг бүрдүүлж байна.

Гэсэн хэдий ч макро эдийн засгийн тогтворгүй байдал, инфляц, валютын ханшийн хэлбэлзэл, зээлийн эрсдэл зэрэг хүчин зүйлс нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад анхаарах шаардлагатай хэвээр байна.

### 3. ЭРХ ЗҮЙ, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

#### Монгол Улсын санхүүгийн салбарын зохицуулах байгууллагууд

№	Зохицуулах байгууллага	Хариуцдаг салбар	Үндсэн чиг үүрэг
1	Монголбанк	Банкны систем	Арилжааны банкуудын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих
		Төлбөрийн систем	Үндэсний төлбөр тооцооны системийг хөгжүүлэх, зохицуулах
		Мөнгөний бодлого	Инфляц, мөнгөний нийлүүлэлтийг удирдах бодлого хэрэгжүүлэх
2	Санхүүгийн зохицуулах хороо	Банк санхүүгийн байгууллага бус	ББСБ-ын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих



INVESTMENT AND  
TRADE AGENCY



№	Зохицуулах байгууллага	Хариуцдаг салбар	Үндсэн чиг үүрэг
		Даатгал	Даатгалын зах зээлийг зохицуулах
		Хөрөнгийн зах зээл	Үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хөгжүүлэх
		Хадгаламж зээлийн хоршоо	ХЗХ-ны үйл ажиллагаанд хяналт тавих

Эдгээр байгууллагууд нь санхүүгийн салбарын тогтвортой байдал, хэрэглэгчийн хамгаалалт, зах зээлийн ил тод байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

### 3.1. Гадаадын банк Монголд орж ирэх боломж

Хууль, зохицуулалтын хувьд **боломж бий**. Монголын Банкны тухай хуулийн 22 дугаар зүйлд гадаадын хөрөнгө оруулалттай банк, түүний салбар, төлөөлөгчийн газар байгуулах боломжийг тусгасан. Үүнд гадаад банк Монголд үйл ажиллагаа явуулах шийдвэрээ гаргасан байх, өөрийн улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй байх, мөн Монголбанкны шаардсан бусад баримт бичгийг бүрдүүлэх ёстой. Нэмэлт үйл ажиллагааны шаардлагыг Монголбанк журмаараа тогтооно.

Гэхдээ лиценз автоматаар олгогдохгүй. Мөн хуулийн 23 дугаар зүйлд Монголбанк зөвшөөрөл олгохдоо тухайн банк “Улсын эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх эсэх”, хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны эсэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй холбоогүй эсэхийг шалгана гэж заасан. Иймээс Монголд гадаад банк оруулах бодлого нь “нээлттэй ч болгоомжтой” гэж ойлгогдоно.

### 3.2. Яагаад гадаад банк орж ирэх нь давуу байж болох вэ

Нэгдүгээрт, өрсөлдөөн нэмэгдэнэ. Монголын банкны систем төвлөрөл өндөр тул олон улсын тоглогч орж ирвэл үнэ, үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, эрсдэлийн удирдлага, технологийн стандарт сайжрах магадлалтай. Хоёрдугаарт, томоохон төслийн санхүүжилт, худалдааны санхүүжилт, олон улсын төлбөр тооцоо, кастодиан, хөрөнгө удирдлага, хөрөнгийн зах зээлийн дагалдах үйлчилгээ зэрэгт гадаад банк илүү хүчтэй байж болно. Гуравдугаарт, финтек ба төлбөрийн системийн интеграц хурдсах боломжтой. Монголбанк өөрөө төлбөрийн систем, финтек инновацыг 2024 оноос илүү идэвхтэй дэмжиж эхэлсэн нь ийм нэвтрэлтийн суурь болж байна.

### 3.3 Яагаад бодит амьдрал дээр амаргүй вэ

Нэгдүгээрт, Монголын зах зээл жижиг. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 13.19 их наяд төгрөг, ББСБ-ын нийт актив 8.5 их наяд төгрөг гэдэг нь өсөлттэй ч бүс нутгийн том зах зээлүүдтэй харьцуулахад багтаамж хязгаарлагдмал гэсэн үг.

Хоёрдугаарт, макро савлагаа өндөр. ОУВС 2025 онд экспортын орлогын сааралт, инфляц, урсгал дансны дарамт, зээлийн хурдтай өсөлт зэрэг нь ойрын хугацааны эрсдэлийг нэмэгдүүлсэн гэж үзсэн. Ийм орчинд шинэ гадаад банк зах зээлд орж ирэхэдээ ашигт ажиллагаанаас илүү эрсдэлийн үнэлгээг чухалчилна.

Гуравдугаарт, зохицуулалт нь нээлттэй боловч хатуу шүүлтүүртэй. Монголбанк эдийн засгийн аюулгүй байдал, AML/CFT, эх үүсвэрийн хууль ёсны байдлыг шалгадаг тул зөвхөн том, нэр хүндтэй, урт хугацааны стратегитай тоглогч л бодитоор орж ирэх боломжтой.

### 3.4. Эрсдэл, тогтвортой байдлын асуудал

#### Санхүүгийн салбарын тогтвортой байдалд нөлөөлөх эрсдэлүүд

№	Эрсдэлийн төрөл	Тайлбар	Нөлөөллийн түвшин	Болзошгүй нөлөө
1	Макро эдийн засгийн савлагаа	Уул уурхай, экспорт, эдийн засгийн өсөлтийн хэлбэлзэл	Маш өндөр	Санхүүгийн системийн тогтворгүй байдал
2	Зээлийн чанарын эрсдэл	Зээлийн эргэн төлөлт муудах, чанаргүй зээл өсөх	Өндөр	Банкуудын ашигт ажиллагаа буурах
3	Инфляц	Үнийн өсөлт, худалдан авах чадвар буурах	Өндөр	Зээлийн эрэлт, хадгаламжид нөлөөлөх
4	Валютын ханшийн хэлбэлзэл	Төгрөгийн ханш сулрах, гадаад өрийн дарамт	Өндөр	Валютын эрсдэл нэмэгдэх
5	Кибер аюулгүй байдлын эрсдэл	Дижитал банк, төлбөрийн системд халдлага	Дунд	Мэдээллийн алдагдал, системийн доголдол

Санхүүгийн салбарын тогтвортой байдалд макро эдийн засгийн савлагаа, зээлийн чанар, инфляц зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлдөг.

Иймээс санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахын тулд эрсдэлийн удирдлага, зохицуулалтын бодлогыг сайжруулах шаардлагатай байдаг.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын банк, санхүүгийн салбар нь 2020–2025 оны хугацаанд хэмжээ, үйлчилгээ, дижитал хөгжлийн хувьд тогтвортой өсөлттэй байж, эдийн засгийн чухал тулгуур салбар хэвээр байна. Банкны салбар санхүүгийн системийн үндсэн хэсгийг бүрдүүлж байгаа хэдий ч банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгийн зах зээл, финтек үйлчилгээ зэрэг дэд салбаруудын хөгжил эрчимжиж, санхүүгийн зах зээл аажмаар төрөлжих хандлага ажиглагдаж байна.

Салбарын хүрээнд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт өндөр хэвээр байгаа бөгөөд хэрэглээний болон бизнесийн зээл, хадгаламж, цахим төлбөрийн үйлчилгээ хамгийн их эрэлттэй байна. Ялангуяа финтек, дижитал санхүүгийн үйлчилгээний хөгжил нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг идэвхжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Хөрөнгө оруулалтын хувьд банк, санхүүгийн салбар нь финтек, төлбөрийн систем, банк бус санхүүжилт, хөрөнгийн зах зээл, ногоон санхүүжилт зэрэг чиглэлүүдэд өндөр боломжтой байна. Гэсэн хэдий ч гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ харьцангуй бага, зах зээлийн гүнзгийрэлт сул байгаа нь салбарын хөгжлийг хязгаарлаж буй хүчин зүйлсийн нэг хэвээр байна.

Мөн тус салбар нь үйлчилгээний гадаад худалдаанд идэвхтэй оролцож, экспорт, импортын аль алинд оролцон валютын урсгал болон төлбөрийн тэнцэлд нөлөөлж байна. Энэ нь Монгол Улсын санхүүгийн салбар олон улсын интеграцид нэгдэж байгааг илтгэж байгаа боловч гадаад үйлчилгээний хамаарал өндөр байгаа нь эрсдэл дагуулж болзошгүй юм.

Нөгөөтэйгүүр макро эдийн засгийн савлагаа, инфляц, валютын ханшийн хэлбэлзэл, зээлийн чанарын эрсдэл, кибер аюулгүй байдлын асуудлууд нь салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйлс хэвээр байна.

Иймд Монгол Улсын банк, санхүүгийн салбарын тогтвортой хөгжлийг хангахын тулд хөрөнгийн зах зээлийг гүнзгийрүүлэх, финтек болон дижитал санхүүгийн инновацийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мөн эрсдэлийн удирдлага, зохицуулалтын бодлогыг сайжруулах шаардлагатай байна.

## **ЭХ СУРВАЛЖ**

1. Монголбанк. (2024). Санхүүгийн тогтвортой байдлын тайлан
2. Санхүүгийн зохицуулах хороо. (2024) Санхүүгийн зах зээлийн тайлан.



INVESTMENT AND  
TRADE AGENCY



3. Үндэсний статистикийн хороо. (2024) Санхүүгийн статистик.
4. Олон улсын байгууллагуудын Монголын санхүүгийн салбарын судалгааны материал.